

МЭРГЭЖЛИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД НӨЛӨӨЛЖ БУЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

/Хэргийн газрын үзлэгийн жишээн дээр/

Г.Ганхүлэг

ШШЕГ-ын Эрдэм шинжилгээ, сургалт, хөгжүүлэлтийн төвийн чиглэлийн ахлах мэргэжилтэн. шинжлэн магадлахуйн доктор (Ph.D). цагдаагийн хошvvч

Товч агуулга: Энэхүү судалгааны зорилго нь мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл, сургалтын үйл ажиллагаа ажлын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийг судлахад оршино. Судалгааны зорилгоо биелүүлэхийн тулд Шүүх шинжилгээний ерөнхий газрын төв, нийслэл, аймагт ажиллаж буй 85 мэргэжилтэн, Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн судлаачдаас урьдчилан боловсруулсан асуулгын хуудсаар судалгаа авсан. Судалгааг 2022 оны 11-р сараас 12-р сарын хооронд онлайнаар авч нэгтгэсэн ба судалгаандаа SMART PLS 3.0 болон SPSS 25.0 программыг ашиглан хэмжил зүйн, хамаарлын, олон хүчин зүйлийн, замын шинжилгээ хийхдээ шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын хүрээнд тухайн хүчин зүйлийн хувьсагчид шинжээч, мэргэжилтэн хэргийн газрын үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх, ямар хамааралтайг нотлох оролдлого хийж, үр дүнг нэгтгэлээ. Бид Шүүх шинжилгээний ерөнхий газрын шинжээч, мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлс, түүний үр дагаврыг судлахдаа дөрвөн таамаглалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд тэдгээрийн хоёр нь эерэг, хоёр нь сөрөг нөлөөлөлтэй байв.

Түлхүүр үгс: мэргэжлийн мэдлэг, ур чадвар, техник хэрэгсэл, сургалт, ажлын гүйцэтгэл

Гүйцэтгэл гэдэг нь тухайн хүн болон түүний ажлын шаардлага, сургалт, хөгжил, зан үйлийн хоорондын харилцан үйлчлэлийн хэмжигдэхүйц үр дүн юм.¹ Ажлын гүйцэтгэл нь микро түвшин (хувь хүн), мезо түвшин (бүлэг) болон макро түвшин (байгууллага) гэсэн гурван түвшний үр дүнд нөлөөлдөг чухал хувьсагч юм. Ажлын орчин, удирдлагын дэмжлэг нь ажлын гүйцэтгэлд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг (шууд ба шууд бус) бол дасан зохицох чадвар, дотоод сэдэл нь ажлын гүйцэтгэлд шууд нөлөөлдөг болохыг харуулж байна.²

Ажилчдын гүйцэтгэл нь зөвхөн ур чадварын түвшин ямар байхаас

хамаардаггүй. Хувь хүний ур чадварын түвшинг хадгалах нь тухайн байгууллагын сургалт, хөгжлийн философиор тодорхойлогддог. Ажилтны гүйцэтгэл нь удирдлагын үр нөлөө, ажилчдад зориулсан багаж хэрэгсэл, технологи, ажлын физик орчин, дижитал ажлын орчин зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг.

Хөдөлмөрийн харилцааны аль ч түвшинд төвлөрсөн хот, суурин, жижиг сум, баг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага ер нь хаана ч ажлын гүйцэтгэл, байдаг бөгөөд ажлын гүйцэтгэл буюу хөдөлмөрийн зорилго үр дүнд чиглэгдэж байдаг. Энэ бүхэн гүйцэтгэл дээр үндэслэдэг бөгөөд

¹ <https://trainingindustry.com/articles/performance-management>

² Pandey, J. (2019), "Factors affecting job performance: an integrative review of

literature", *Management Research Review*, Vol. 42 No. 2, pp. 263-289.

гүйцэтгэл сайн бол үр дүн, ач холбогдол өсөн нэмэгдэж байгууллагын зорилгод хүрэх боломж нээлттэй болдог.

Байгууллагын зорилго нь гүйцэтгэлийг өндөр байлгаж, үр ашгийг нэмэгдүүлэхэд оршдог бөгөөд гүйцэтгэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Үүрэг даалгаврын биелэгдсэн түвшинг гүйцэтгэл гэнэ.

- Аливаа үйлдлийн болон үйл ажиллагааны үйл явц, арга хэлбэр юм.


- Гүйцэтгэл нь мэдлэг эзэмшсэнээр мэдлэгийг хэрэглэснээр аливаа ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгэх үйлдэл юм.

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэж үзвэл ажлын гүйцэтгэл гэдэг нь мэдлэгээ ашиглан үүрэг даалгаврыг

биелүүлэх үйл ажиллагаа, түүний арга хэлбэр юм гэж ойлгож болохоор байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх буюу хэргийн газрын үзлэг хийхэд ямар хүчин зүйл шууд хамааралтайгаар нөлөөлж байгааг илрүүлэх, нийгмийн шинжлэх ухаан болох менежментийн онол арга зүйн ажлын гүйцэтгэлийн суурь онол, эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнд тулгуурлан энэхүү судалгааны ажлын таамаглал дэвшүүлсэн. Дээрх судалгааны ажлын онол, онолын суурь ойлголтод нөлөөлж байгаа хүчин зүйлийн уялдаа холбоог дэмжин судалж, судалгааны ажлын таамаглалд үндэслэн загварыг дараах байдлаар гаргав.

Зураг 1. Хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлсийн уялдаа



Таамаглал-1: Мэргэжлийн мэдлэг нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-2: Ур чадвар нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-3: Техник хэрэгсэл нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.


Таамаглал-4: Сургалтын үйл ажиллагаа нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Судалгааны үр дүнгийн боловсруулалт:

Судалгаанд шүүх шинжилгээний байгууллагын 85 шинжээч, мэргэжилтнийг хамруулсан ба чанарын судалгаагаар, хүчин зүйлийн шинжилгээ, хэмжил зүйн

шинжилгээ, хамаарлын шинжилгээ, замын шинжилгээний боловсруулалт хийн үр дүнг гаргасан. Үүнд:

Зураг 2. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн (algorithm)



Тайлбар: Prof kn-мэргэжлийн мэдлэг; prof sk-мэргэжлийн ур чадвар, tech meas-техник, хэрэгсэл, tra ac - сургалтын үйл ажиллагаа; pr mgt-ажлын гүйцэтгэл

Хэмжилзүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал хэсэг бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулан шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр ажлын гүйцэтгэлд (хэргийн газрыг үзлэгт) хэрхэн нөлөөлж байгааг харуулах ба, хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронпа альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ. Найдвартай байдлын хэмжүүрийг дараах томъёогоор тодорхойлон үр дүнг гаргасан.


Томъёо №1.
$$\alpha = \frac{N\bar{e}}{\bar{e} + (N-1)\bar{e}}$$

Томъёоны тайлбар: N-далд хувьсагчийн тоо, $\bar{e}$ -дундаж дисперс, $\bar{e}$ -дундаж ковариация

Бидний судалгааны ажлын хувьд далд хувьсагчдын хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг 5 хувьсагчаар 4 замаар таамаглал дэвшүүлэн батлах оролдлогоор шинжилгээ хийсэн.

Далд хувьсагч нь ажлын гүйцэтгэлд ажиглагдсан ковариацийг тайлбарлахын тулд ашигласан таамаглал юм. Ижил далд хувьсагчдад хамаарах ажиглагдсан хувьсагчдын хоорондын хамаарал нь: Бидний судалгаагаар мэргэжлийн ур чадвар гүйцэтгэлийн удирдлагатай ($r=0.596$), мэргэжлийн ур чадвар мэргэжлийн мэдлэгтэй ($r=0.742$) өндөр хамааралтай байсан.

Зураг 3. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн (Bootstrapping)



Тайлбар: Prof kn-мэргэжлийн мэдлэг; prof sk-мэргэжлийн үр чадвар, tech meas-техник, хэрэгсэл, tra ac -сургалтын үйл ажиллагаа; pr mgt-ажлын гүйцэтгэл

Хүснэгт 1. Далд хувьсагч тус бүрийн жагсаалт

Factors	Items	results of items	Cronbach's alpha	CR	AVE
Professional knowledge	Prof kn -1	0.636	0.713	0.794	0.361
	Prof kn -2	0.475			
	Prof kn -3	0.657			
	Prof kn -4	0.705			
	Prof kn -5	0.672			
	Prof kn -6	0.439			
	Prof kn -7	0.568			
Professional skills	Prof sk-1	0.551	0.870	0.899	0.563
	Prof sk-2	0.789			
	Prof sk-3	0.760			
	Prof sk-4	0.809			
	Prof sk-5	0.760			
	Prof sk-6	0.727			
	Prof sk-7	0.824			
Technical measurement	Tech meas-1	0.866	0.887	0.904	0.573
	Tech meas-2	0.863			
	Tech meas-3	0.869			
	Tech meas-4	0.885			
	Tech meas-5	0.825			
	Tech meas-6	-0.014			
	Tech meas-7	0.859			
Training activity	Tra ac-1	0.695	0.877	0.905	0.574
	Tra ac-2	0.753			
	Tra ac-3	0.836			
	Tra ac-4	0.796			
	Tra ac-5	0.897			
	Tra ac-6	0.720			
	Tra ac-7	0.681			
PERFORMANCE MANAGEMENT	PR MGT-1	0.289	0.883	0.906	0.503
	PR MGT-2	0.724			
	PR MGT-3	0.799			
	PR MGT-4	0.527			
	PR MGT-5	0.772			
	PR MGT-6	0.744			
	PR MGT-7	0.780			
	PR MGT-8	0.802			
	PR MGT-9	0.656			
	PR MGT-10	0.821			

Тайлбар: Prof kn-мэргэжлийн мэдлэг; prof sk-мэргэжлийн ур чадвар, tech meas-техник, хэрэгсэл, tra ac - сургалтын үйл ажиллагаа; pr mgt-ажлын гүйцэтгэл

“Мэргэжлийн мэдлэг”-ийг 7 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.439-0.705** хооронд хэлбэлзэж байна. Мэргэжлийн мэдлэгийн кронпа альфа утгын үр дүн **0.713**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.794** байгаа нь манай судалгааны ажлын үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Дундаж утгын хувьд **0.361** байв.

“Мэргэжлийн ур чадвар”-ийг 7 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.551-0.824** хооронд хэлбэлзэж байна. Мэргэжлийн ур чадварын кронпа альфа утгын үр дүн **0.870**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.899** байгаа нь манай судалгааны ажлын үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Дундаж утгын хувьд **0.563** байв.

“Техник хэрэгсэл”-ийг 7 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд

далд хувьсагчийн үр дүн **-0.014-0.885** хооронд хэлбэлзэж байна. Техник хэрэгслийн кронпа альфа утгын үр дүн **0.887**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.904** байгаа нь манай судалгааны ажлын үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Дундаж утгын хувьд **0.573** байв.

“Сургалтын үйл ажиллагаа”-г 7 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.681-0.836** хооронд хэлбэлзэж байна. Сургалтын үйл ажиллагааны кронпа альфа утгын үр дүн **0.887**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.905** байгаа нь манай судалгааны ажлын үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Дундаж утгын хувьд **0.574** байв.

“Ажлын гүйцэтгэл”-ийг 10 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.289-0.821** хооронд хэлбэлзэж байна. Ажлын гүйцэтгэлийн кронпа альфа утгын үр дүн **0.883**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.906** байгаа нь манай судалгааны ажлын үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Дундаж утгын хувьд **0.503** байв.

Хүснэгт 2. Судалгааны загвар дахь замын шинжилгээний үр дүн

№	Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хазайлт	Т Статистик	П үнэ цэнэ	ҮР ДҮН
1	Мэргэжлийн мэдлэг → АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0,197	0,114	1,536	0,125	батлагдаагүй
2	Мэргэжлийн ур чадвар → АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0,329	0,121	2,855	0,004	батлагдсан
3	Техник, хэрэгсэл→ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0,032	0,118	0,276	0,783	батлагдаагүй
4	Сургалтын үйл ажиллагаа → АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0,309	0,084	3,696	0,000	батлагдсан

Мэргэжлийн мэдлэг нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө гэсэн

таамаглалын үр дүнгийн дундаж утга 0.197, Стандарт хазайлт 0.114, Т

статистик утга 1.536, П үнэ цэнэ 0.125 гарч батлагдсангүй. Мэргэжлийн ур чадвар нь ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн дундаж утга 0.329, Стандарт хазайлт 0.121, Т статистик утга 2.855, П үнэ цэнэ 0.004 гарч батлагдсан. Техник, хэрэгсэл нь ажлын гүйцэтгэлд эеэгээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн дундаж утга 0.032, Стандарт хазайлт 0.118, Т статистик утга 0.276, П үнэ цэнэ 0.783 гарч батлагдсангүй. Сургалтын үйл ажиллагаа ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө гэсэн таамаглалын үр дүнгийн дундаж утга 0.309, Стандарт хазайлт 0.084, Т статистик утга 3.696 гарч, П үнэ цэнэ 0.000 утгатай тус тус гарч таамаглал батлагдсан.

Дүгнэлт

Гүйцэтгэлийн менежмент болон нийгмийн шинжлэх ухааны мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, техникийн хэмжилт, сургалтын үйл ажиллагаа зэрэг бусад үзүүлэлтүүдийг хэрхэн уялдуулах талаар судалсан. Бид SMART PLS-3.0 хэмээх чанарын судалгааны программыг хэмжилзүйн, харилцан хамаарал, олон хүчин зүйл, эмгэг судлалд дүн шинжилгээ хийж, төрийн албанд бүтээлч үйл ажиллагааг сургах талаар багаар ажиллах, сургалтын оролцоо, сургалтын орчны үр дүнг нэгтгэн дүгнэх, мэргэжлийн мэдлэг нь гүйцэтгэлийн удирдлагад эерэг нөлөөлнө, мэргэжлийн ур чадвар гүйцэтгэлийн удирдлагад эерэг нөлөө үзүүлнэ, техникийн хэмжилт эерэг нөлөө үзүүлнэ гэсэн дөрвөн таамаглал дэвшүүлсэн. Судалгааны үр дүнд ажлын гүйцэтгэлтэй холбоотой хоёр таамаглал эерэг байсан ч хоёр таамаглал сөрөг байсан. Мэргэжлийн ур чадвар болон сургалтын үйл ажиллагаа

нь ажлын гүйцэтгэлтэй холбоотой эерэг нөлөө үзүүлнэ;

Бид энэхүү судалгааны ажлаар шинжээч, мэргэжилтний хэргийн газрын үзлэг хийх ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хувьсагчийн талаар илүү дэлгэрүүлэн судлах, дараа дараагийн судлаачдын судалгааны ажлын суурь судалгаа болгох, хэргийн газрын үзлэгийн гүйцэтгэл хэрхэн хэрэгжиж байгааг хянан судалсан. Судалгааны ажлын хэмжил зүй, хүчин зүйлийн шинжилгээг хийхдээ сөрөг гарсан далд хувьсагчийг тайлбарлах байдлаар бичсэн нь судалгааны ажлын ач холбогдлыг харуулсан гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Pandey, J. (2019), "Factors affecting job performance: an integrative review of literature", Management Research Review, Vol. 42 No. 2

- Bader Alyoubi, Rakibul Hoque, Ibraheem Alharbi, Adel Alyoubi, Najah Almazmomi. (2018), "Impact of Knowledge Management on Employee Work Performance: Evidence from Saudi Arabia", The International Technology Management Review, Vol. 7, No. 1

- Hassan M. E. Aboazoum, U. Nimran, M. A. Musadieq. (2015), Analysis Factors Affecting Employees Job Performance in Libya,

- Maureen Mwaiko. (2013), Factors affecting employee performance Assessment in the education sector in Tanzania: a Case study of Pugu secondary school,

- Li Wang, Kunhui Ye, Yu Liu, Wenjing Wang (2022) Factors affecting expert performance in bid evaluation: An integrated approach,

- Tengpongsthorn, W. (2016) Factors affecting the effectiveness of

police performance in Metropolitan Police Bureau

- <https://mn.wikipedia.org/performance-management>
- <https://www.emerald.com/>

- <https://trainingindustry.com/articles/performance-management>

- <https://www.digital-adoption.com/employee-performance/>